

2020 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх хэсэг, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 4 сарын 19-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2020 оны 12 сарын 31-ний байдлаарх санхүүгийн тайланд “Грант Торнтон Аудит” ХХК аудит хийж, гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Ганхуяг)-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ